



**МОНГОЛ УЛСЫН
САНГИЙН САЙДЫН ТУШААЛ**

___ оны ___ сарын ___-ны өдөр

Дугаар___

Улаанбаатар хот

Аргачлал батлах тухай

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.6, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2 дахь заалтын тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ыг нэгдүгээр хавсралтаар, “ашигт малтмал, цацраг идэвхт ашигт малтмал, газрын тосны хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрлийн үнэлгээ тооцох, татварын ногдлыг тодорхойлох аргачлал”-ыг хоёрдугаар хавсралтаар, “Эрх борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах журам”-ыг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

Хоёр. Батлагдсан аргачлал, журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Татварын ерөнхий газар /Б.Заяабал/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төсвийн бодлого, төлөвлөлтийн газар /Ж.Ганбат/, Төсвийн хяналт, эрсдэлийн удирдлагын газар /Н.Нарангэрэл/-т тус тус даалгасугай.

Дөрөв. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Сангийн сайдын 2017 оны 379, 380 дугаар тушаалуудыг хүчингүй болсонд тооцсугай.

Ч.ХҮРЭЛБААТАР

ГАЗАР ЭЗЭМШИХ, АШИГЛАХ ЭРХИЙН ҮНЭЛГЭЭ ТООЦОХ, ТАТВАРЫН НОГДЛЫГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Хувь хүн, хуулийн этгээдийн газар эзэмших, ашиглах эрх борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг тодорхойлоход энэхүү аргачлалыг баримтална.

1.2.Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлсэн бол Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д заасанчлан орлого олсон гэж үзэж, албан татвар ногдуулах орлогын хэмжээг тухайн газрын дуудлага худалдааны анхны үнээс багагүй байхаар тооцно.

Хоёр. Газар эзэмших, ашиглах эрхийн үнэлгээ тооцох

2.1.Газрын эрх борлуулсан, шилжүүлсний орлогод албан татвар ногдуулах орлогыг Газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.5-д заасны дагуу эрх бүхий байгууллагаас баталсан “Газар эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааны анхны үнийг тодорхойлох аргачлал”-ын дагуу тооцсон дуудлага худалдааны анхны үнээс багагүй байх зарчмыг баримтална тодорхойлно.

2.2.Энэ аргачлалын 2.3, 2.4 дэх хэсэгт зааснаас бусад тохиолдолд тухайн газрыг дуудлага худалдаагаар авахад шалгарсан үнэ болон татвар төлөгчөөс мэдүүлсэн газрын эрх худалдах, худалдан авах гэрээний үнийн аль өндөр үнээр газрын эрхийн үнэлгээг тодорхойлно.

2.3.Газрын эрхийг өөр төрлийн хөрөнгө, үйл ажиллагаагаар харилцан солилцсон, эсхүл дуудлага худалдаагаар олгогдоогүй газрын эрх борлуулж, шилжүүлж байгаа тохиолдолд газрын эрхийн үнэлгээг энэ аргачлалын 2.1-д заасан үнэ болон татвар төлөгчөөс ирүүлсэн газрын эрх борлуулах, шилжүүлэх гэрээний үнийн дүнгийн аль өндөр дүнгээр газрын эрхийн үнэлгээг тодорхойлно.

2.4.Бусдаас үнэ төлбөргүй авсан газрын эрхэд албан татвар ногдуулах орлогыг Татварын ерөнхий хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу энэ аргачлалын 2.1-д зааснаар тодорхойлно.

2.5.Газрын эрхийн дуудлага худалдааны анхны үнийг холбогдох аргачлалаар тодорхойлох боломжгүй тохиолдолд Газрын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1-д зааснаар тухайн шатны Засаг дарга тодорхойлно.

Гурав. Газар эзэмших, ашиглах эрх борлуулах, шилжүүлэхэд албан татвар ногдуулах орлогыг тодорхойлох

3.1.Газар эзэмших, ашиглах эрх борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд албан татвар ногдуулах орлогыг энэ аргачлалын хоёрдугаар хэсэгт зааснаар тодорхойлсон газрын эрхийн үнэлгээнээс дор дурдсан баримтаар нотлогдох зардлуудыг хасаж тодорхойлно.

3.1.1.төрийн байгууллагаас эрх олгосон тохиолдолд эрх авахтай холбогдон төрийн байгууллагад төлсөн баримтаар нотлогдох төлбөр, хураамж;

3.1.2.бусдаас худалдаж, шилжүүлж авсан тохиолдолд хэлцлийн дагуу худалдах, шилжүүлэн авахад төлсөн, шилжүүлсэн баримтаар нотлогдох төлбөр.

3.2. Энэ аргачлалын 3.1.2-т заасан төлбөрт хууль тогтоомжийн дагуу албан татвар ногдуулан төлөөгүй тохиолдолд уг төлбөрийг албан татвар ногдуулах орлогоос хасаж тооцохгүй .

3.3.Үл хөдлөх эд хөрөнгийг түүний газрын хамт борлуулсан, шилжүүлсэн тохиолдолд газрын эрхийг борлуулсан, шилжүүлсэнтэй адилтган үзэж тухайн газрын талбайн хэмжээнд үндэслэн энэ аргачлалын 2 дугаар хэсэгт зааснаар албан татвар ногдуулах орлогыг тодорхойлно.

---oOo---

